

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/43/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Мөнхтулга

Утас: 70432545

цахим хаяг: munkhtulga.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт	11
4.1 Залруулсан алдаа.....	11
4.2 Төлбөрийн акт.....	11
4.3 Зөвлөмж	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав бас Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

Г САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН
АЛБАНЫ ДАРГА Г.ӨӨДЭЙ ТАНАА

2022.02.21 № 02/45
таний _____-ны № _____-г

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын Баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын өс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Засгийн газрын тогтоолыг зөрчин төсвийн тодотголоор батлагдсан төсвийг нэмэгдүүлсэн, Сангийн яамнаас хянасан орон тоог нэмэгдүүлсэн, тэтгэвэрт гарсан хүний орон тоог царцаагаагүй, байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй ажилд шатахуун зарцуулсан, Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг шилэн дансны сайтад байршуулаагүй, улсын байцаагчийн үнэмлэхийн хугацаа дууссан байхад ажил хавсарсны нэмэгдэл авсан зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах" Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", Өрсөлдөөний тухай хуулийн 14.4-д "Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч, орон нутагт улсын байцаагч ажиллана", 14.5-д "Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга улсын ерөнхий байцаагч байх бөгөөд тэрээр улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг томилж, чөлөөлнө", 20.1-д "энэ хуулийн 14.4-д заасан улсын байцаагч Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас баталсан албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ", Шилэн дансны тухай хуулийн 6.1.6-д "төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр

00102025

батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.2-д "Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх", Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1 дүгээр хавсралтын 15-д "Ажилтан ажлаас халагдах үед ажил олгогч нь түүнтэй ээлжийн амралтын тооцоог заавал хийнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, "Үнэн зөв байх", "Иж бүрэн байх", "Тохиолдсон байх", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.Б.ОЛДБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,671,114.00</u>	<u>4,075,554.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	3,671,114.00	4,075,554.00
354	Хангамжийн материал	3,671,114.00	4,075,554.00
35410	Бичиг хэргийн материал	1,604,460.00	1,419,900.00
35470	Бусад хангамжийн материал	2,066,654.00	2,655,654.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>12,681,267.31</u>	<u>9,530,117.47</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12,681,267.31	9,530,117.47
392	Биет хөрөнгө	12,040,642.30	9,226,992.46
39203	Авто-тээврийн хэрэгсэл	15,000,000.00	15,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(8,541,666.55)	(11,041,666.51)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	11,232,400.00	13,487,400.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(8,936,074.84)	(10,879,749.84)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,649,900.00	5,649,900.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,363,916.31)	(2,988,891.19)
393	Биет бус хөрөнгө	640,625.01	303,125.01
39301	Програм хангамж	1,350,000.00	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(709,374.99)	(1,046,874.99)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>16,352,381.31</u>	<u>13,605,671.47</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>4,635,920.28</u>	<u>755,813.18</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,635,920.28	755,813.18
413	Өглөг	4,635,920.28	755,813.18
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,395,920.28	755,813.18
4136	Бусад өглөг	240,000.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	240,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>11,716,461.03</u>	<u>12,849,858.29</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	11,716,461.03	12,849,858.29
512	Хуримтлагдсан үр дүн	11,716,461.03	12,849,858.29
51210	Өмнөх үеийн үр дүн	11,716,461.03	11,716,461.03
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,133,397.26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>16,352,381.31</u>	<u>13,605,671.47</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	145,285,500.00	213,570,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	145,285,500.00	213,570,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	145,285,500.00	213,570,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	145,285,500.00	213,570,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	154,373,824.21	212,437,502.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	154,373,824.21	212,437,502.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	152,373,824.21	183,424,602.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	99,214,817.65	141,384,363.36
210101	Үндсэн цалин	68,185,017.79	101,158,920.36
210102	Нэмэгдэл	28,470,254.86	33,607,443.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,559,545.00	6,618,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,389,707.15	18,721,875.54

210201	Тэтгэврийн даатгал	8,508,002.54	12,985,860.86
210202	Тэтгэмжийн даатгал	908,183.66	1,449,753.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	744,220.90	1,143,002.94
210204	Ажилгүйдлийн даатгал	246,945.73	285,750.73
210205	Эрүүл мэндийн даатгал	1,982,354.32	2,857,507.34
2104	Хангамж, бараа материалын зардал	9,461,200.00	7,119,418.00
210401	Бичиг хэрэг	1,877,694.00	1,973,360.00
210402	Тээвэр, шатахуун	5,160,400.00	4,302,658.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,167,700.00	818,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	255,406.00	24,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,643,800.00
210604	Урсгал засвар	-	1,643,800.00
2107	Томилолт, зочны зардал	9,500,000.00	8,301,350.00
210702	Дотоод албан томилолт	9,500,000.00	8,301,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,756,595.48	151,046.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,599,999.48	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	110,000.00	91,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	74,250.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	92,346.00	32,346.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	27,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	858,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,051,503.93	6,102,749.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	250,000.00	114,580.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	408,100.00	582,020.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,393,403.93	5,406,149.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00	29,012,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	29,012,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	27,646,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	1,366,700.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(9,088,324.21)	1,133,397.26

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,716,461.03	11,716,461.03
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,716,461.03	11,716,461.03
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз		-
C07	Тайлант үеийн үр дүн		-
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,716,461.03	11,716,461.03
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	11,716,461.03	11,716,461.03
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,716,461.03	11,716,461.03
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		-
D08	Тайлант үеийн үр дүн	1,133,397.26	1,133,397.26
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,849,858.29	12,849,858.29

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	145,285,500.00	213,570,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	145,285,500.00	213,570,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	145,285,500.00	213,570,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	145,285,500.00	213,570,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	145,285,500.00	213,570,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	145,285,500.00	213,570,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	143,285,500.00	184,258,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	94,202,900.00	140,450,756.62
210101	Үндсэн цалин	63,173,100.00	88,444,505.89
210102	Нэмэгдэл	28,470,254.86	33,615,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,559,545.14	3,244,955.62
210105	Гэрээт ажлын хөлс	-	15,145,795.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,717,300.00	18,839,543.38
210201	Тэтгэврийн даатгал	8,835,595.39	13,332,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	908,183.66	1,403,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	744,220.90	1,015,843.38
210204	Ажилгүйдлийн даатгал	246,945.73	280,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,982,354.32	2,806,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,935,300.00	7,629,700.00
210401	Бичиг хэрэг	2,107,200.00	1,813,800.00
210402	Тээвэр, шатахуун	5,160,400.00	4,302,658.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,167,700.00	1,513,242.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	350,000.00	1,935,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	350,000.00	291,700.00
210604	Урсгал засвар	-	1,643,800.00
2107	Томилолт, зочны зардал	9,500,000.00	8,301,400.00
210702	Дотоод албан томилолт	9,500,000.00	8,301,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,780,000.00	1,871,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,600,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	110,000.00	91,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	80,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	110,000.00	41,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	18,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	858,000.00	1,687,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	33,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.00	5,229,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	4,645,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	583,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00	29,312,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	29,312,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	27,646,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	1,666,700.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	213570900.00	213570900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	213570900.00	213570900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	184258000.00	184258000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	140343800.00	140450756.62
210101	Үндсэн цалин	89972100.00	88444505.89
210102	Нэмэгдэл	33615500.00	33615500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2156200.00	3244955.62
210105	Гэрээт ажлын хөлс	14600000.00	15145795.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18946500.00	18839543.38
210201	Тэтгэврийн даатгал	13332700.00	13332700.00
210202	Тэтгэмжийн даатгал	1403400.00	1403400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1122800.00	1015843.38
210204	Ажилгүйдлийн даатгал	280700.00	280700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2806900.00	2806900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7835900.00	7629700.00
210401	Бичиг хэрэг	1756000.00	1813800.00
210402	Тээвэр, шатахуун	3440200.00	4302658.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,639,700.00	1,513,242.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	625,000.00	1,935,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	291,700.00	291,700.00
210604	Урсгал засвар	333,300.00	1,643,800.00
2107	Томилолт, зочны зардал	9,288,400.00	8,301,400.00
210702	Дотоод албан томиллолт	9,288,400.00	8,301,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,989,200.00	1,871,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	91,700.00	91,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	66,700.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	91,700.00	41,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	18,300.00	18,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,687,500.00	1,687,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	33,300.00	33,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,229,200.00	5,229,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,645,900.00	4,645,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	583,300.00	583,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,312,900.00	29,312,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,312,900.00	29,312,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,646,200.00	27,646,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,666,700.00	1,666,700.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	213,570,900.00	213,570,900.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	213,570,900.00	213,570,900.00
132001	Орон нутгийн төсвөөс	213,570,900.00	213,570,900.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	8	11
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	5	9
620003	Үйлчлэх ажилтан	2	1
620004	Гэрээт ажилтан	-	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Мөнхтулга 2022 оны 01 дүгээр сарын 21-нээс 2021 оны 01 дугаар сарын 26-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 19-ны өдрийн 23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Санхүүгийн хяналт, аудитын алба нь “Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Засаг даргын дэргэдэх төсөвт байгууллага болон ОНӨААТҮГ-ууд, тусгай сангуудад Хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино” гэсэн зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- *Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төсөвт байгууллагуудад санхүүгийн хяналт хэрэгжүүлэх, зөвлөн туслах, дотоод аудитыг хэрэгжүүлэх*
- *Засгийн газрын шийдвэр болон харьяалах дээд шатны шийдвэрийг гүйцэтгэлийг хянах*
- *Харьяа яамны сайдын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд “Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт” сэдэвт гүйцэтгэлийн аудитын хүрээнд Ховд аймгийн

Төрийн аудитын газраас тус байгууллагад санхүүгийн хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 213.6 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 2.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1.5 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2.8 сая төгрөгөөр буюу 17.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Тайлант оны эхэнд болон эцэст авлагын данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 4.1 сая төгрөг болж 0.4 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 8.9 сая төгрөгийн бараа материал худалдан авч үйл ажиллагаандаа 8.5 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 33.2 сая төгрөг, оны эцэст 35.5 сая төгрөг болж 2.3 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 2.3 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсантай холбоотой байна.

Оны эхэнд 4.6 сая төгрөгийн өр төлбөртэй байсан бол тайлант онд өр төлбөрийг бүрэн барагдуулан ажиллаж оны эцэст 0.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 11.7 сая төгрөг байсан оны эцэст 12.8 сая төгрөг болж тайлант онд 1.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 12.8 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 213.6 сая төгрөгөөр, нийт зарлагыг 213.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 213.6 сая төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 213.6 сая төгрөгийн төсөв баталснаас 213.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 213.6 сая төгрөг нийт 213.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 213.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 213.6 сая төгрөг буюу 100 хувьтай байна. Хангамж бараа материалын зардлыг 0.2 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 1.3 сая, хэтрүүлэн томилолтын зардлыг 1.0 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 0.1 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 139 мэдээллийг хугацаандаа оруулсан, 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 3 мэдээлэл оруулах хугацаа болоогүй байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 12 ажил гүйлгээг шилэн дансны сайтад байршуулаагүй, байгууллагын батлагдсан төсвийг буруу мэдээлсэн, аудитын зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4.9 сая төгрөгийн 6 зөрчилд зөвлөмж өгөгдсөн бөгөөд 83.3 хувь хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 43.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1.1 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт бичиж, 42.8 сая төгрөгийн 2 алдаа зөрчилд албан шаардлага, 1 зөвлөмж бичигдлээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулсан алдаа байхгүй болно.

4.2 Төлбөрийн акт

1. Байгууллагын үйл ажиллагаанд зарцуулагдаагүй 0.4 сая төгрөгийн шатахууны зардлыг төсвөөс төлж авлагаар бүртгээгүй нийт 4.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах” Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 5-р зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, гэсэн хуулийн заалт, аудитын “Үнэн зөв байдал”, “Иж бүрэн” байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Тус байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан албан хаагчид амралтын эцсийн тооцоо бодож олгоогүйтэй холбоотой 0.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1 дүгээр хавсралтын 15-д “Ажилтан ажлаас халагдах үед ажил олгогч нь түүнтэй ээлжийн амралтын тооцоог заавал хийнэ” гэсэн заалт, аудитын “Үнэн зөв байх”, “Иж бүрэн” байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Буцаан олгох төлбөрийн акт тогтоов.

Албан шаардлага

1. Тайлант онд сангийн яамнаас баталсан орон тоог 3-аар нэмэгдүүлсэн, батлагдсан төсвийг 39.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн батлуулж зарцуулсан, тэтгэвэрт гарсан ажилтны орон тоог царцаахгүйгээр шинээр ажилтан авсан, батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”, 1.2-д “Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.
2. Тус байгууллагын дарга нь улсын байцаагчийн эрхийн хугацаа дууссан байхад ажил хавсарсны нэмэгдэлд 3.7 сая төгрөгийн цалин авсан нь Өрсөлдөөний тухай хуулийн 14.4-д “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч, орон нутагт улсын байцаагч ажиллана”, 14.5-д “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга улсын ерөнхий байцаагч байх бөгөөд тэрээр улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг томилж, чөлөөлнө”, 20.1-д “энэ хуулийн 14.4-д заасан улсын байцаагч Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас баталсан албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.3.1 Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны хуульд заасан 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлогын гүйлгээг цахим сайтад мэдээлээгүй, байгууллагын батлагдсан төсвийг буруу мэдээлсэн, аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.6-д “төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр,” Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан журмын заалтын дагуу холбогдох мэдээллийг байршуулаагүй зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль хууль, журамд заасны дагуу мэдээллийг үнэн зөв мэдээлж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/сая төгрөгөөр/							
				Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		

1	Санхүүгийн хяналт, аудитын алба	5	43.9	0	0	2	1.1	2	42.8	1	0
---	---------------------------------	---	------	---	---	---	-----	---	------	---	---

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР